**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БУА-2021/170/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2021 он


Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Anhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном
Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

Аудитор: А.Сувдаа
Утас: 70342495 Цахим хаяг: Suvdaaa@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| **УСНББОУС** | **Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт** |
| **АДБОУС** | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| **АОУС** | Аудитын Олон Улсын Стандарт |
| | |
| | |
| | |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....12
3.Аудитын тайлан....13
3.1. Ерөнхий зүйл....13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....14
3.4. Материаллаг байдал ....14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....16
3.7. Шилэн дансны мэдээлэл....17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....17
3.9. Аудитын илрүүлэлт....17
Залруулсан алдаа....17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....18
Аудитын зөвлөмж....18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....18
4. Менежментийн захидал ....18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....**Error! Bookmark not defined.**

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.18 № 51

Танай ____________-ны № ________________т

БУЛГАН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.БАТЖАРГАЛ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

0060501 9

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

# 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **63,118,081.26** | **60,017,180.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 639,995.00 | 1,219,995.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 639,995.00 | 1,219,995.00 |
| **3121** | **Төгрөг** | 639,995.00 | 1,219,995.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 639,995.00 | 1,219,995.00 |
| **33** | **АВЛАГА** | 5,249,701.00 | 2,700,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,249,701.00 | 2,700,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 57,228,385.26 | 56,097,185.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 521,960.00 | 1,012,730.00 |
| 35130 | Эм боох материал | 521,960.00 | 1,012,730.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 56,706,425.26 | 55,084,455.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,671,292.00 | 1,160,292.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 40,683,493.40 | 38,318,303.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 70,000.00 | 140,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,680,809.00 | 1,968,350.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 540,500.00 | 445,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,288,030.86 | 2,231,010.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,772,300.00 | 10,821,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,275,741,009.28** | **1,270,292,603.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,275,741,009.28 | 1,270,292,603.94 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,135,524,009.28 | 1,130,135,603.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,181,226,864.46 | 1,181,226,864.46 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -109,099,086.24 | -196,128,683.12 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 137,530,630.00 | 137,530,630.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -134,280,630.22 | -137,530,630.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 171,227,306.19 | 203,462,364.01 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -134,317,172.86 | -104,025,492.04 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 70,311,178.00 | 69,722,733.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -47,075,080.05 | -24,122,182.37 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 140,217,000.00 | 140,157,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -125,000.00 | -185,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 140,042,000.00 | 140,042,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,338,859,090.54** | **1,330,309,783.94** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,338,859,090.54** | **1,330,309,783.94** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,338,859,090.54 | 1,330,309,783.94 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 418,151,929.90 | 418,151,929.90 |
| 51101 | Өмч: - төрийн | 278,109,929.90 | 278,109,929.90 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 140,042,000.00 | 140,042,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 429,547,565.12 | 420,998,258.52 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 429,547,565.12 | 427,182,864.12 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -6,184,605.60 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 491,159,595.52 | 491,159,595.52 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,338,859,090.54** | **1,330,309,783.94** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **698,954,713.00** | **834,005,268.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **130,648,198.00** | **193,290,768.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 130,648,198.00 | 193,290,768.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 130,648,198.00 | 193,290,768.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1200,000,00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 102,170,800.00 | 88,199,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 28,477,398.00 | 103,891,768.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **567,666,520.00** | **640,714,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 530,880,200.00 | 627,793,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 530,880,200.00 | 627,793,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 639,995.00 | 1,200,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 36,786,320.00 | 12,921,000.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 476,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 800,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,795,120.00 | 12,921,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 11,715,200.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **805,532,263.32** | **840,189,873.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **805,532,263.32** | **840,189,873.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 788,904,918.44 | 786,451,961.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 404,037,097.00 | 456,533,580.66 |
| 210101 | Үндсэн цалин | 303,179,973.00 | 349,846,259.16 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 72,533,300.00 | 93,795,801.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,323,824.00 | 12,891,520.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,516,300.00 | 57,336,832.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,351,000.00 | 43,845,199.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,041,300.00 | 4,024,401.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,233,100.00 | 2,312,094.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 808,300.00 | 370,721.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,082,600.00 | 6,784,415.01 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,444,150.00 | 37,610,654.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,853,880.00 | 4,897,994.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,573,270.00 | 25,420,320.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,017,000.00 | 7,292,340.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 46,640,466.00 | 23,445,139.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,511,080.00 | 5,176,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,390,032.00 | 4,189,159.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,512,170.00 | 2,428,090.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 375,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 275,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,906,820.00 | 3,769,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 27,320,364.00 | 7,231,790.40 |
| **2105** | **Нормативт зардал** | 31,905,899.68 | 25,961,190.86 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 211,210.00 | 867,940.00 |
| 210502 | Хоол, хүнс | 29,019,419.68 | 21,773,010.86 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,675,270.00 | 3,320,240.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,508,652.00 | 5,029,360.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,508,652.00 | 5,029,360.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,394,000.00 | 1,597,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,394,000.00 | 1,597,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 57,851,192.70 | 62,166,861.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 56,079,597.70 | 59,519,181.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 680,000.00 | 1,188,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 594,610.00 | 564,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 176,485.00 | 158,130.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 68,500.00 | 361,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 175,000.00 | 299,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 141,607,161.06 | 116,770,743.34 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,123,120.00 | 2,157,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 133,484,041.06 | 114,613,743.34 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,627,344.88 | 53,737,912.33 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,664,982.00 | 23,872,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 22,052,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,664,982.00 | 1,820,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,962,362.88 | 29,865,412.33 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,962,362.88 | 29,865,412.33 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-106,577,550.32** | **-77,018,223.60** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-106,577,550.32** | **-77,018,223.60** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **670,477,315.00** | **730,613,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **102,170,800.00** | **89,899,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 102,170,800.00 | 89,899,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 102,170,800.00 | 89,899,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,700,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 102,170,800.00 | 88,199,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **568,306,515.00** | **640,714,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 530,880,200.00 | 627,793,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 530,880,200.00 | 627,793,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 639,995.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 36,786,320.00 | 12,921,000.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 476,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 800,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,795,120.00 | 12,921,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 11,715,200.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **661,049,430.00** | **724,648,930.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **661,049,430.00** | **724,648,930.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **644,022,085.12** | **670,811,017.67** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 404,037,097.00 | 456,848,580.66 |
| 210101 | Үндсэн цалин | 303,179,973.00 | 350,161,259.16 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 72,533,300.00 | 93,795,801.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,323,824.00 | 12,891,520.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,516,300.00 | 57,336,832.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,351,000.00 | 43,845,199.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,041,300.00 | 4,024,401.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,233,100.00 | 2,312,094.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 808,300.00 | 370,721.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,082,600.00 | 6,784,415.01 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,523,400.00 | 42,942,654.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,853,880.00 | 4,897,994.00 |
| 210302 | Түлш, халаалт | 25,652,520.00 | 30,752,320.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,017,000.00 | 7,292,340.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,099,922.00 | 18,107,780.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,967,350.00 | 3,964,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,920,100.00 | 3,712,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,512,170.00 | 2,428,090.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 1,044,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,700,302.00 | 6,958,290.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 40,322,000.00 | 23,641,780.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,200,000.00 | 1,190,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,083,210.00 | 18,113,220.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,038,790.00 | 4,338,560.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,718,800.00 | 4,960,130.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,907,800.00 | 4,915,130.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,811,000.00 | 45,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,037,000.00 | 1,597,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,037,000.00 | 1,597,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 60,644,446.12 | 62,454,661.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 58,218,651.12 | 59,586,981.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 680,000.00 | 1,188,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 594,610.00 | 564,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 176,485.00 | 158,130.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 722,700.00 | 581,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 175,000.00 | 299,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,123,120.00 | 2,921,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,123,120.00 | 2,921,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,027,344.88** | **53,837,912.33** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 11,064,982.00 | 23,972,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 22,052,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,064,982.00 | 1,920,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,962,362.88 | 29,865,412.33 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,962,362.88 | 29,865,412.33 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,427,885.00** | **5,964,570.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,787,890.00** | **5,384,570.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,787,890.00** | **5,384,570.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,787,890.00 | 5,384,570.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,787,890.00 | 5,384,570.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-8,787,890.00** | **-5,384,570.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 639,995.00 | 580,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 639,995.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 639,995.00 | 1,219,995.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 278,109,929.90 | 82,536,000.00 | 1,113,151,642.73 | 00.00 | 1,473,797,572.63 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -5,828,206.16 | 00.00 | -5,828,206.16 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **278,109,929.90** | **82,536,000.00** | **1,107,323,436.57** | **00.00** | 1,467,969,366.47 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 140,042,000.00 | 00.00 | -572,154,895.03 | 00.00 | -432,112,895.03 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418,151,929.90** | **491,159,595.52** | **429,547,565.12** | **00.00** | 1,338,859,090.54 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418,151,929.90** | **491,159,595.52** | **429,547,565.12** | **00.00** | 1,338,859,090.54 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -2,364,701.00 | 00.00 | -2,364,701.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **418,151,929.90** | **491,159,595.52** | **427,182,864.12** | **00.00** | 1,336,494,389.54 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -6,184,605.60 | 00.00 | -6,184,605.60 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **418,151,929.90** | **491,159,595.52** | **420,998,258.52** | **00.00** | 1,330,309,783.94 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 627,518,200.00 | 627,413,965.12 | 726,767,500.00 | 717,112,500.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 627,518,200.00 | 627,413,965.12 | 726,767,500.00 | 717,112,500.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 625,468,200.00 | 625,363,965.12 | 703,402,500.00 | 668,038,587.67 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 404,079,500.00 | 404,037,097.00 | 461,528,800.00 | 456,848,580.66 |
| 210101 | Үндсэн цалин | 316,713,200.00 | 303,179,973.00 | 350,707,500.00 | 350,161,259.16 |
| 210102 | Нэмэгдэл | 72,533,300.00 | 72,533,300.00 | 95,938,300.00 | 93,795,801.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,833,000.00 | 28,323,824.00 | 14,883,000.00 | 12,891,520.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,516,300.00 | 50,516,300.00 | 62,306,300.00 | 57,336,832.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,351,000.00 | 34,351,000.00 | 43,845,200.00 | 43,845,199.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,041,300.00 | 4,041,300.00 | 4,615,300.00 | 4,024,401.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,233,100.00 | 3,233,100.00 | 3,692,300.00 | 2,312,094.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 808,300.00 | 808,300.00 | 923,000.00 | 370,721.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,082,600.00 | 8,082,600.00 | 9,230,500.00 | 6,784,415.01 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 41,523,400.00 | 41,523,400.00 | 51,522,800.00 | 42,942,654.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,260,200.00 | 6,853,880.00 | 8,260,200.00 | 4,897,994.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,246,200.00 | 25,652,520.00 | 33,742,600.00 | 30,752,320.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,017,000.00 | 9,017,000.00 | 9,520,000.00 | 7,292,340.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,405,100.00 | 13,404,922.00 | 16,221,300.00 | 14,280,780.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,844,400.00 | 2,462,350.00 | 1,867,000.00 | 1,867,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,097,100.00 | 5,097,100.00 | 4,828,700.00 | 2,912,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,767,100.00 | 1,145,170.00 | 1,499,200.00 | 1,498,090.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 1,044,700.00 | 1,044,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,696,500.00 | 4,700,302.00 | 6,981,700.00 | 6,958,290.00 |
| **2105** | **Норматив зардал** | 40,055,000.00 | 40,055,000.00 | 30,359,300.00 | 23,641,780.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,200,000.00 | 1,190,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,500,000.00 | 33,816,210.00 | 24,804,300.00 | 18,113,220.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,355,000.00 | 5,038,790.00 | 4,355,000.00 | 4,338,560.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,806,700.00 | 16,806,700.00 | 10,366,700.00 | 10,344,700.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,995,700.00 | 9,995,700.00 | 10,321,700.00 | 10,299,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,811,000.00 | 6,811,000.00 | 45,000.00 | 45,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 00.00 | 188,600.00 | 188,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 00.00 | 188,600.00 | 188,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 55,656,100.00 | 55,644,446.12 | 70,908,700.00 | 62,454,661.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 53,222,200.00 | 53,218,651.12 | 67,944,100.00 | 59,586,981.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 680,000.00 | 680,000.00 | 1,200,000.00 | 1,188,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 595,000.00 | 594,610.00 | 595,000.00 | 564,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 178,200.00 | 176,485.00 | 178,200.00 | 158,130.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 83,000.00 | 77,000.00 | 83,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 722,700.00 | 722,700.00 | 583,400.00 | 581,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 175,000.00 | 175,000.00 | 325,000.00 | 299,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 0.00 | 23365000.00 | 23972500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 23,365,000.00 | 23,972,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 00.00 | 22,052,500.00 | 22,052,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,050,000.00 | 2,050,000.00 | 1,312,500.00 | 1,920,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 627,518,200.00 | 633,690,995.00 | 726,767,500.00 | 717,192,500.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 530,880,200.00 | 531,520,195.00 | 627,793,500.00 | 628,993,500.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 530,880,200.00 | 530,880,200.00 | 627,793,500.00 | 627,793,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 00.00 | 00.00 | 1,200,000.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 96,638,000.00 | 102,170,800.00 | 98,974,000.00 | 88,199,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 96,638,000.00 | 102,170,800.00 | 98,974,000.00 | 88,199,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **00.00** | **00.00** | 00.00 | 639,995.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | 00.00 | 1,219,995.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 00.00 | 00.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 41.00 | 00.00 | 41.00 | 41.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 34.00 | 34.00 | 34.00 | 34.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 06.00 | 06.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 08.00 | 00.00 | 00.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **00.00** | **00.00** | **35.00** | **00.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 35.00 | 35.00 | 35.00 | 00.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **12,921,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **12,921,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 8,157,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 3,827,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 2,097,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 930,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 1,409,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,409,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 2921000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2,921,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **4,764,000.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 4,764,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 12921000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 12,921,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 12,921,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Н.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн нийцэл, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 3-аас 2021 оны 02 дугаар сарын 18–ны Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хоёр дахь шатны, аудитын менежер Ж.Энхцоодол, ахлах аудитор П.Содном нар анхан шатны хяналтыг тус тус хэрэгжүүлэн, аудитор А.Сувдаа хариуцан гүйцэтгэв.

Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь төрийн аудитын газар-т 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/40 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Зорилтот бүлгийн өрхийн амьжиргааг дэмжих, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн цогц үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийнхээ амьдралд тохирсон нийгмийн эрсдэлийг зөөлрүүлсэн, үйлчлүүлэгч төвтэй, мэргэшсэн чадварлаг ёс зүйг дээдэлсэн манлайлагч байгууллага болохыг тулд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулан, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үйлчлүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэхэд оршино" зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай /2020 оны 163 дугаар тогтоол/
- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай /ЗГ-ын 472 дугаар тогтоол/

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "16803.8 мянган төгрөг" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 388354.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7767.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8549.3 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 639.9 | 1219.9 | 580.0 |

| | | | |
|---|---|---|---|
| Авлага | 5249.7 | 2700.0 | -2549.7 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 57228.4 | 56097.2 | -1131.2 |
| Үндсэн хөрөнгө | 1275741.0 | 1270292.6 | -5448.4 |
| **Нийт хөрөнгө** | 1338859.1 | 1330309.8 | -8549.3 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1338859.1 | 1330309.8 | -8549.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1338859.1 | 1330309.8 | -8549.3 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 639.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1219.9 мянган төгрөгийн ахмадын сангийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 5249.7 болон эцсийн үлдэгдэл 2700.0 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 56097.2 мянган төгрөг болж 1131.2 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалаас 6504.5, бичиг хэргийн материалаас 176.0, хүнсний материалаас 497.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгаснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдлийн 68.3 хувийг аж ахуйн материал данс дахь бараа материал эзэлж байна. Эдгээр аж ахуйн материалд буй хөрөнгийн ихэнх нь ахмадын амралтын бараа материал бөгөөд үндсэн хөрөнгийн шинжтэй олон жил болсон бараа материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1270292.6 мянган төгрөг болж 5448.4 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийг акталж, дахин үнэлснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 5384.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 32947.2 мянган төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 70833.6 мянган төгрөгийн  хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 0 мянган төгрөг, акталсан 77518.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй бөгөөд урт хугацаат өр төлбөр үүсээгүй  байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл  1330309.8 мянган төгрөг болж 8549.3 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал акталсан, элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлж тайлагнаснаас шалтгаалжээ.

2020-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 135050.6 мянган төгрөгөөр буюу  19.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны орлого байна. Энэ нь зарим албан хаагчийн цалингийн шатлал нэмэгдсэн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл авах болсонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 34657.6 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардал байна. Энэ нь цалингийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 2364.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь олон жил болсон авлагын талаар ажлын хэсэг гарч ажиллан дүн шинжилгээ хийн хасагдах авлага гэж үзсэнээс шалтгаалсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 799751.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 799751.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 57743.6 мянган төгрөгөөр бууруулж 742007.9 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант хугацаанд нийт 3 удаагийн тодотгол хийн нийт 726767.5 мянган төгрөг болгон баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, ажил олгогчоос олгох тэтгэмж арга хэмжээг санхүүжүүлэхээр 726767.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 627793.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 98974.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 627793.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 88199.0 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1200.0 мянган төгрөг, нийт 717192.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 717112.5 мянган төгрөгийг зарцуулж 25101.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 717112.5 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 4680.2, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 4969.5, байр ашиглалттай холбоотой зардлыг 8580.1, хангамж бараа материалын зардлыг 1940.5, норматив зардлыг 6717.5, эд хогшил худалдан авах зардлыг 22.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 8454.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээ 20073.3 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ арга хэмжээ 5015.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж арга хэмжээ 12.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 12921.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэрэгт 2009.0 мянга, тээвэр шатахуунд 800.0 мянга, шуудан холбоонд 930.0 мянга, дотоод албан томилолт 1409.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 2921.0 мянга нийт 12921.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 136 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 0 мэдээлэл, 10 удаагийн тушаал шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Тус байгууллага нь шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мэдээллийг байршуулахдаа 1 удаагийн орлого, зарлагын нийт 27887.5 мянган төгрөгийн мэдээллийг дутуу байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5249.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг 54.6 хувийг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 3169.2 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | 1 | 5249.7 | 1 | 2864.7 | | 2385.0 | 45.4 |
| Зөвлөмж | 5 | 3169.2 | 5 | 3169.2 | 0 | 0 | 0 |
| Нийт дүн | 6 | 8418.9 | 6 | 6033.9 | 0 | 2385.0 | 45.4 |

Хэрэгжүүлээгүй 2385.0 мянган төгрөгийн зөвлөмжийн үлдэгдлийг барагдуулах ажлыг тус байгууллага зохион байгуулж шүүхэд шилжүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10533.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8453.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 435.4 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 1645.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн урьдчилгаагаар олгосон 1900.0 мянган төгрөгийг барагдуулсан.
2. Албан томилолтоор ажилласан үед 33.0 мянган төгрөгийн хоолны нэмэгдэл давхардуулж олгосныг холбогдох ажилтнуудаас суутгасан.
3. Эхний хагас жилийн байдлаар бараа материалыг нярав 2033.9 мянган төгрөгийн орлого авахдаа материал хүлээж авсан өдрөөр бус хэд хоногийн дараа орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснийг тухай бүрд нь орлого авхуулж залруулав.
4. Эхний хагас жилийн байдлаар 4486.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь барагдуулж өглөгийн үлдэгдэлгүй тайлагнасан.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 435.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Үр дүнгийн урамшуулал олгохдоо 435.4 мянган төгрөгийг илүү олгосныг нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: аудитын хугацаанд барагдуулав

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 1645.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1.Өглөг, авлагын данстай холбоотой асуудал*

*1.1.Илрүүлэлт:* Тайлант хугацаанд 315.0 мянган төгрөгийн авлага үлдэгдэлтэй

*1.2.Эрсдэл:* Дотоод хяналт сулрах,

1.3.*Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”

*1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрч байна. Цаашид анхааран ажиллах

*2. Зардлын данстай холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:* Цалингийн зардлаас 1200.0 мянган төгрөгийг ахмадын сангийн дансанд шилжүүлсэн байна.

*2.2. Эрсдэл:* Хууль журам мөрдөгдөхгүй байх

*2.3. Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 41.2.2, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1.3 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

*3.Шатахуунтай холбоотой асуудал*

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

*3.1. Илрүүлэлт* "Ник" ХХК-тай байгуулсан Ник/46 дугаар бүхий худалдан авах гэрээнд үнийн дүнгийн 3 хувиар хөнгөлөлт эдлэхээр заагдсан ч тайлант хугацаанд 4347.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж 130.4 мянган төгрөгийн урамшуулал авахаас хөнгөлөлтийг эдлээгүй авлага үүсгээгүй байна.

*3.2. Эрсдэл*: Гэрээ мөрдөгдөхгүй байх, орлого дутуу орох, санхүүгийн тайлан буруу гарах

*3.3. Өгсөн зөвлөмж:* Худалдан авалт гэрээний биелэлтийг бүрэн хангах, гэрээнд хөнгөлөлт урамшууллыг тодорхой тусгах

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

*4. Бараа материалтай холбоотой асуудал*

*4.1. Илрүүлэлт:* Аж ахуйн материалд бүртгэлтэй ахмадын амралтын олон жил болсон үндсэн хөрөнгийн шинжтэй 136 тооны 13184.3 мянган төгрөгийн хөрөнгө байна.

*4.2. Эрсдэл*: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

*4.3. Өгсөн зөвлөмж:* Хөрөнгийн ангиллын залруулга хийж, УСНББОУС-ын холбогдох заалтыг хэрэгжүүлж, өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнах

*4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

*5.Шилэн данстай холбоотой асуудал*

*5.1. Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 10 тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.

*5.2. Эрсдэл*: Хууль, журам зөрчигдөх, хариуцлага хүлээх

*5.3. Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6.4.8, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 2.2.3.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

*5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР А.СУВДАА